



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№88 /532/

2023.05.30

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

ХИЛИЙН ЧАНАДАД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЖ БУЙ ЦЭНХЭР ДУУЛГАТНУУДАА БАЯР ХҮРГЭЖ, АМЖИЛТ ХҮСЛЭЭ



“Олон улсын энхийг сахиулагчдын өдөр”-ийг тохиолдуулан Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба нар БНӨСУ, Баруун Сахар, БНАКонгоУ, Йемэн Улс, Мали Улс, ТАБНУ болон Абей мужийн нутаг дэвсгэрт явагдаж буй энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй цэнхэр дуулгатнуудтай цахим уулзалт хийж, баярын мэнд дэвшүүлэв.

Энэ үеэр хилийн чанадад үүрэг гүйцэтгэж буй цэргийн багийн удирдлага, бие бүрэлдэхүүн, НҮБ-ын цэргийн ажиглагч болон штабын офицеруудын төлөөлөл үүрэг гүйцэтгэлт, ажиллагааны газар орны цагийн байдлын талаар тус тус илтгэж, санал хүсэлтээ уламжилсан юм. Батлан хамгаалах яам, удирдлагын зүгээс салбарын хууль тогтоомжийг үе шаттайгаар шинэчлэх, богино, дунд, урт хугацааны бодлого,

төлөвлөлтийн баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах хүрээнд Зэвсэгт хүчний энхийг сахиулах ажиллагааны оролцоо, боломжийг нэмэгдүүлэх, цаашид удирдах албан тушаалтны тоог ахиулах, “Мотобуудлагын батальон”, “Түргэн байрлах хүчний рот”, “Инженерийн рот”, “Цэргийн хээрийн хоёрдугаар шатны эмнэлэг”-ийг оролцуулах, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс гаргасан “Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал” тогтоолын дагуу энхийг сахиулах ажиллагаанд эмэгтэй алба хаагчдын тоог үе шаттай нэмэгдүүлж, улмаар 15 хувьд хүргэх зэрэг томоохон ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байгааг Батлан хамгаалахын сайд онцоллоо.

Мөн “Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын сэтгэл зүйн байдал маш чухал. Иймд цэргийн багийн удирдлагууд алба хаагчдынхаа сэтгэлзүйг нь мэдэрч, ар гэрийнх нь аж байдал, үр хүүхдийнх нь хичээл сурлага, байр байдлыг байнга судалж, анхаарал хандуулах

хэрэгтэй. Бие бүрэлдэхүүн эв нэгдэлтэй, сахилга, дэг журмыг чанд мөрдөж, цэргийн багийн удирдлага, шат шатны дарга, захирагч нарын тушаалыг чанд сахин биелүүлээрэй. Ингээд та бүхэндээ Олон Улсын Энхийг сахиулагчдын өдрийн баярын мэндийг хүргэхийн ялдамд гэр бүл үр хүүхдэд нь энэ хорвоогийн хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Монгол Улс Та бүхнээр бахархаж байгаа. Төр, түмнийхээ төлөө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж байгаад салбарын сайдын хувьд талархаж байгаагаа илэрхийлье” гэлээ.

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс энхийг дэмжих ажиллагаанд 2002 оноос өнөөг хүртэлх хугацаанд 21000 гаруй цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэсэн бол өнөөдөр дэлхийн 7 улс, мужид явагдаж буй НҮБ-ын мандаттай 9 ажиллагаанд 900 орчим цэргийн алба хаагч үүргээ амжилттай гүйцэтгэж байна.

БНЭУ-ЫН ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН КОЛЛЕЖИЙН СТРАТЕГИЙН ДАМЖААНД СУРАЛЦАГСАД МОНГОЛ УЛСАД АЙЛЧИЛЖ БАЙНА



нь олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдал, олон улсын хууль, эрх зүй, улс төр, эдийн засаг, олон улсын байгууллага, стратегийн харилцаа, стратеги судлал, аюулгүй байдлын сорилт зэргийг нэг жилийн хугацаанд судлах бөгөөд сургалтын хөтөлбөрийн дагуу бүс нутгийн орнуудаар аялаж, тэдгээрийн улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжил, соёлтой танилцах боломжтой гоороо онцлог юм.



БНЭУ-ын Үндэсний батлан хамгаалахын коллежийн Стратегийн дамжаанд суралцаж буй Оросын холбооны Улс, Бүгд найрамдах Энэтхэг Улс, Мьянмарын холбооны бүгд найрамдах Улс, Холбооны бүгд найрамдах Бразил Улс, Израил Улс, Оманы Султант Улсын генерал, ахлах офицерууд энэ сарын 28-наас ирэх сарын 3-ны өдрийг хүртэлх хугацаанд манай улсад айлчилж байна.

Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай төлөөлөгчдийг хүлээн авч уулзан Монгол Улсын батлан хамгаалах бодлого, бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар санал солилцлоо. Дэд сайд Б.Баярмагнай зочдод хандаж

хэлсэн үгэндээ “Та бүхэн Монгол Улсад ажиллах хугацаандаа манай орны онцлог, аюулгүй байдал, улс төр, нийгэм, эдийн засгийн байдалтай танилцаж, аялалынхаа дараа энэхүү бүс нутгийн талаар илүү мэдлэгтэй болж дараагийн ажил албандаа илүү үр бүтээлтэйгээр ажиллана гэдэгт итгэлтэй байна” хэмээгээд нийт бүрэлдэхүүнд ажлын амжилт хүсэв.

БНЭУ-ын Үндэсний батлан хамгаалахын коллежийн Аюулгүй байдал, стратегийн дамжаа нь цэргийн болон иргэний өндөр албан тушаалтныг бэлтгэдэг, олон улсад нэр хүндтэй сургалтуудын нэг юм. Тус дамжаанд суралцагч



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	☁️ 8

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38	☁️ 29

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,440	3,448
EUR 🇪🇺	3,690	3,715
CNY 🇨🇳	487	489
RUB 🇷🇺	41.60	42.30
JPY 🇯🇵	24.70	25
KRW 🇰🇷	2.56	2.59

ЗУРХАЙ

2023.05.30 /МЯГМАР ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 10

**ЗУНЫ ТЭРГҮҮН УЛААГЧИН
МОГОЙ САР
НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАР
ХУЛГАНА ӨДӨР**

Үс засуулбал:
Эрч хүч ихэснэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
04.59-20.40
Барилдлага:
Хүчин төгсөх
Шүтэн барилдлага:
Хуран үйлдэхүй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян үйл үйлдвээс элзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээхэд сайн, үсэг зурхайд суралцах, бэрийн болон буяны үйл, дайсныг дарахад сайн. Нохой уливал хааны хэрэг болох, хэрээ дуугарвал өөрийн цусыг үзэх, тагнай загатнавал гэрт үзэсгэлэн болох, бүх бие татвал эд алдах, хөлийн мах татвал сайн гэдэг.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 689,478,914

Эдгэрсэн

Нийт: 661,920,672

Нас барсан

Нийт: 6,884,014

Цахим шууданд

ЗАЛУУ ОФИЦЕРУУД ЧУУЛЖ, САНАЛ ХҮСЭЛТЭЭ ИЛЭРХИЙЛЭВ



Монгол Улсын Зэвсэгт хүчин 2023-2024 оныг “Залуу офицеруудын манлайллын жил” болгон зарласан. Үүнтэй холбогдуулан залуу офицеруудынхаа дуу хоолойг сонсож, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлон төр, засгийн бодлогод тусгах зорилгоор өнөөдөр ЗХЖШ-аас 35 хүртэлх насны офицеруудын төлөөлөлтэй хуралдааныг зохион байгуулав.

Хуралдаанд ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, ТЦК, БИЦУГ-ын харьяа нэгтгэл, анги, байгууллагын офицеруудын төлөөлөл танхим болон цахим хосолсон хэлбэрээр хамрагдаж санал хүсэлтээ ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах тэргүүтэй удирдлагуудад уламжилсан юм.

Тухайлбал, залуу офицеруудын зүгээс Монгол Улсын Зэвсэгт хүчин тэр дундаа алс хол

байршилтай хөдөөгийн нэгтгэл, анги, салбаруудад хүний нөөцийн нөхөн хангалт учир дутагдалтай байгаагийн улмаас нэг хүнд ноогдох ажлын ачаалал нэмэгдэж цаашлаад ар гэрийн амьдралд ч нөлөөлж байгаа талаар илэрхийлж байв.

Мөн алба хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжих нь нэн тэргүүний асуудал болж буйг илэрхийлж байлаа. Тухайлбал, Залуу офицеруудын хувьд үр хүүхэдтэй болох нь нэг талаас тухайн ам бүлийг санхүүгийн гүн дарамтад оруулах эрсдэлтэй байна гэв.

Түүнчлэн ахмад болон залуу үе хоорондын харилцааны зөрчил цөөнгүй ажиглагдах болсон төдийгүй нэгнээ харилцан хүндэтгэх замаар соёлтой, орчин үеийн боловсон хандлагыг эрхэмлэн ажиллах нь алба хаагчдын албандаа хандах хандлага,

ажлын байрны хамт олонч уур амьсгалыг нэмэгдүүлэх, цаашлаад ажлын үр бүтээмжийг сайжруулах олон талтай гэдгийг онцолж байлаа.

Энэ үеэр ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах хэлсэн үгэндээ “Монгол Улсын төр, эдийн засгийн байдал тогтворгүй байгаа хэдий ч ЗХЖШ-ын зүгээс алба хаагчдынхаа нийгмийн хамгааллыг сайжруулах, цалин хөлсийг нэмэгдүүлэх чиглэлээр олон төрлийн судалгаа, шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэн Батлан хамгаалах сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулсан. Эл хуралдаанаас гарсан санал хүсэлтийг мөнбид судалж нэгтгэсний дараагаар холбогдох удирдлагуудад танилцуулна. Энэ завшааныг ашиглаад Монгол Улсын Зэвсэгт хүчний ачааны хүндийг нуруундаа үүрч яваа залуучууддаа талархал илэрхийлье” хэмээлээ.

ЦЭРЭГ СПОРТЫН ДӨЛ ТЭМЦЭЭН, “БИД ЭХ ОРНЫ ИРЭЭДҮЙ” ТӨСӨЛ АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ



Хүүхэд залууст цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилго бүхий Дархан-Уул аймгийн Засаг даргын нэрэмжит цэрэг спортын “Дөл” цогцолбор тэмцээн, “Бид эх орны ирээдүй” төслийн шагнал гардуулах арга хэмжээ боллоо.

Тэмцээнд нийт 10 сургуулийн 10 тасаг өрсөлдсөнөөс 3-р байранд “Оюуны-Ирээдүй” цогцолбор сургуулийн “Соёмбо” тасаг 2-р байранд 16-р сургуулийн “Жигүүртэн” тасаг 1-р байранд 18-р сургуулийн “Харцага” тасаг шалгарч цомын эзэд боллоо. Тусгай байрт шалгарсан сурагчдад Соёл урлагийн газраас гарын бэлэг, гутгаар байрт шалгарсан хүүхдүүдэд Дархан хотын соёл амралтын хүрээлэнгээс үнэ төлбөргүй тоглох эрхийн бичиг, Дэд байрт шалгарсан хүүхдүүдэд Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас хүүхэд хөгжлийн ордны дугуйланд 1 сар үнэ төлбөргүй сурах эрхийн бичиг, Тэргүүн байрт шалгарсан болон амжилттай оролцсон сурагчдад Төв номын сангийн зүгээс номын санд үнэгүй уншигчдын карт нээлгэх

эрхийн бичгээр тус тус шагналаа. Мөн аймгийн Засаг дарга өөрийн зүгээс Өргөө кино театрт кино үзэх эрх, спорт зааланд 5 удаа тоглох эрхээр шагналаа.

“Бид эх орны ирээдүй” төсөл 2022 оны 10 дугаар сарын 15-аас 2023 оны 5 дугаар сарын 27-ны өдөр хүртэлх хугацаанд 2 үе шаттай зохион байгуулагдаж төслийн хүрээнд нийт 9 арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж ЕБС-ийн 1300 гаруй хүүхэд залуучууд оролцсон юм. Энэ хүрээнд зохион байгуулагдсан “Зүрхэнд мөнх эх орон” үндэсний бичгийн уншлагын уралдаанд тэргүүлсэн сурагч, оюутнуудад шагналыг гардууллаа. Мөн төсөлд сургуулийн сурагчдаа идэвхтэй хамруулж нийт явагдсан тэмцээн уралдаанд нийлбэр дүнгээр эхний 3 байр эзэлсэн 16-р сургууль, 4-р сургууль, Орхон сумын 8 дугаар сургуулийн удирдлагууд болон төсөлд дэмжлэг үзүүлэн хамтарч ажилласан байгууллагуудад өргөмжлөл дурсамж гардууллаа.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЦЭРГИЙН ШТАБ

“ДӨЛ-2023” ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭН СЭЛЭНГЭ АЙМАГТ...



Сэлэнгэ аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “ДӨЛ-2023” цогцолбор тэмцээнийг 5 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Тэмцээний гарааны өмнөх ажиллагааг 5 дугаар сарын 25-ны өдөр Сүхбаатар сумын “Партизан”-ы талбайд “Жагсаалын үзүүлэх тоглолт”, “Гардан тулааны үзүүлэх тоглолт”, “Галын бэлтгэлийн норматив”, “Тасгийн захирагч”, “Асуулт харуулт”, “Эсээ” бичлэг, “Гэрийн даалгавар” гэсэн 7 төрлөөр зохион байгуулсан бол тэмцээний хоёр дах өдөр багууд “Энхийн төлөө” марш гүйлтийн тэмцээнийг сугалааны дарааллаар 15 минутын зайтайгаар гараанаас гарч 6 км замыг туулж, гүйлтийн явцад “Гранат шидэлт”, “Буудлага”, “Тактикийн ажиллагаа”, “Эмнэлгийн норматив”, “Цэргийн байр зүй”, “Химийн норматив” гэсэн 6 цэг дээр өгөгдсөн дасгалыг хийж гүйцэтгэсэн юм.

Энэ удаагийн “Дөл-2023” цогцолбор тэмцээнд багийн нийлбэр дүнгээр тэргүүн байрт

Б.Тэмүүжин захирагчтай Мандал сумын ЕБ-ын 2 дугаар сургуулийн “Сүлд” тасаг, дэд байрт Ж.Энх-Амгалан захирагчтай Мандал ЕБ-ын 3 дугаар сургуулийн “Хөх чоно” тасаг, гутгаар байрт Г.Алтан-Эрдэнэ захирагчтай Мандал ЕБ-ын 5 дугаар сургуулийн “Билиг” тасаг, тусгай байрт Б.Сансар захирагчтай Зүүнбүрэн сумын ЕБ-ын сургуулийн “Сүлд” тасаг, Н.Даваажаргал захирагчтай Сүхбаатар сумын ЕБ-ын 5 дугаар сургуулийн “Шонхор” тасаг тус тус шалгарсан бол Тасгийн захирагчийн төрөлд Сайхан сумын Номгон тосгоны ЕБ-ын сургуулийн М.Энхбат, Эсээ бичлэгийн төрөлд Мандал ЕБ-ын 3 дугаар сургуулийн Ж.Энх-Амгалан, жагсаалын үзүүлэх тоглолтын төрөлд Б.Тэмүүжин захирагчтай Мандал сумын ЕБ-ын 2 дугаар сургуулийн “Сүлд” тасаг, Гардан тулааны үзүүлэх тоглолтын төрөлд Ж.Энх-Амгалан захирагчтай Мандал ЕБ-ын 3 дугаар сургуулийн “Хөх чоно” тасаг, Гэрийн даалгаврын төрөлд Б.Сансар захирагчтай Зүүнбүрэн сумын ЕБ-ын сургуулийн “Сүлд” тасаг, Гранат шидэлтийн төрөлд

Б.Тэмүүжин захирагчтай Мандал сумын ЕБ-ын 2 дугаар сургуулийн “Сүлд” тасаг, өргөмжлөл, Тусгай бэлтгэлийн төрөлд М.Тэмүүлэл захирагчтай Ерөө сумын ЕБ-ын сургуулийн “Тэмүүлэл” тасаг, Цэргийн байр зүйн төрөлд Т.Төрболд захирагчтай Сайхан сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн “Дайчин шонхор” тасаг, Тактикийн ажиллагааны төрөлд Л.Уянга захиралтай О.Анар-Эрдэнэ захирагчтай “Элит” тасаг, Галын бэлтгэлийн төрөлд Б.Эрдэнэ-Очир захиралтай Д.Нямбаяр захирагчтай “Бүргэдэй” тасаг тус тус байр эзэлж үеийн олон нөхдөө манлайлсан юм.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЦЭРГИЙН ШТАБ



“МОНГОЛ ЦЭРЭГ-ЭНХИЙН ТӨЛӨӨ”...



Даян дэлхийн энх амгалангийн төлөө хүчин зүтгэсэн Энхийг сахиулагчдын замнал, алдар гавьяаг мөнхжүүлэх, Иргэн-цэргийн харилцаа хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний 032 дугаар бүрэлдэхүүн ерөнхий боловсролын

53 дугаар сургуулийн удирдлага болон ахлах ангийн сурагчдад “Монгол цэрэг-Энхийн төлөө” сэдэвт сургалт, сурталчилгааны ажлыг энэ сарын 29-ны өдөр зохион байгууллаа. Уг арга хэмжээг тус ангийн захирагчийн сургалт бэлтгэл хариуцсан орлогч хошууч Д.Мөнхбаатар

нээж үг хэлж, сургуулийн захиргаанд дурсамж, дурсгалын зүйл гардуулан өгч, хугацаат цэргийн алба хаагчдын бэлтгэсэн жагсаалын үзүүлэх тоглолт, урлагийн хэсэгчилсэн тоглолтыг толилуулан, буудлагын зэвсгийн үзэсгэлэн дэлгэлээ.

Түүнчлэн энхийг дэмжих ажиллагаанд Монгол цэргийн оролцоо, ач холбогдлын талаар сурталчилгаа явуулсан нь сурагчдын сонирхлыг ивэх татсан арга хэмжээ болсон юм. **Ахмад Т.ДЭЛГЭРМАА**